



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 403

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 01 албан даалгаврын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, ажилтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор хийж хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Чанарын менежер (Д.Дашдэлэг)-т даалгасугай.

ДАРГА



Х.ГАНБАТ